



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/514

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
чанар-аюулгүй байдлыг сайжруулах
үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн "Эрүүл мэндийн тухай", "Эмнэлгийн тусламжийн тухай" хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбоотойгоор үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээнийхээ чанарыг олон улсын жишигт ойртуулж, өвчтний аюулгүй байдлыг хангах, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх, эмнэлгийн алдаа зөрчлөөс сэргийлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж зорилтот түвшинд хүргэхийг бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

D:\barimt\tushaal

031695

Эрүүл мэндийн сайдын 2017 оны
12 дугаар сарын 18 өдрийн 4/574
дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР-АЮЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ (2018-2022)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Олон улсын хэмжээнд анагаах ухааны салбар хурдацтай хөгжиж, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчний аюул нэмэгдэж, халдварт бус өвчин, хорт хавдрын өвчлөл хүн төрөлхтний бэрхшээлтэй асуудал болохын хирээр эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанарын асуудал чухлаар тавигдаж байна. Үйлчлүүлэгч төвтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүнд хүргэх нь манай улсын эрүүл мэндийн салбарын төдийгүй дэлхийн олон улс орны эрүүл мэндийн байгууллагуудын эрхэм зорилго болоод байна.

Манай улсын хувьд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд эрүүл мэндийн тусламжийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр ажиллаж, оношилогоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар боловсруулах, чанарын алба, баг, чанарын менежер ажиллуулах тушаал шийдвэр гарч, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны стандарт, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ирсэн.

Гэвч хүн амын дунд өвчлөл ихсэж, эмнэлгийн үйлчилгээний хэрэгцээ осон нэмэгдэж байгаагийн хирээр эрүүл мэндийн байгууллагууд өвчтний буюу үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдлийн удирдлага, эмнэлгийн алдаа зөрчлийг бүртгэх, дүн шинжилгээ хийх, бодитой арга хэмжээ авах талаар хангалтгүй ажиллаж байна. Иргэдийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад итгэх итгэл буурч олон гэр бүл, хувь хүн гадаад орны эмнэлэгт оношилгоо, эмчилгээ хийлгэхээр явж байгаа нь манай улсын иргэдэд санхүүгийн болон сэтгэл санааны маш их бэрхшээл учруулж байгаа төдийгүй улс орны эдийн засагт хохирол учруулсаар байна.

Сүүлийн жилүүдэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, олон улсын бусад байгууллагууд эрүүл мэндийн тусламжийн чанар, өвчтний болон эмнэлгийн аюулгүй байдлын асуудалд ихээхэн анхаарал хандуулж байгаа билээ.

Статистик мэдээгээр эмнэлгийн 10 үйлчлүүлэгч тутмын 1 нь эмнэлгийн ямар нэг алдаа зөрчилд өртөж эрүүл мэнд, цаашлаад амь насаараа хохирч байдгаас улс орнуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах олон систем, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Манай улсын зарим эрүүл мэндийн байгууллага ДЭМБ-ын аюулгүй байдлын хөтөлбөрүүдэд оролцож байна.

АНУ-ын Чикаго хотод төвтэй /Joint Commission International/ магадлан итгэмжлэлийн тогтолцоо нь дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг ба хүсэлт гаргасан эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээ нь олон улсын түвшинд хүрсэн эсэхийг нь магадлан тогтоож батламжлан, 3 жил тутам стандартаа нарийсган итгэмжлэгдсэн, эмнэлгүүдийнхээ тусламжийн чанарыг хөгжүүлдэг.

Монгол улсаас анх удаа "Интермед" эмнэлэг 2016 оны 8 дугаар сард "JCI" олон улсын магадлан итгэмжлэлийг авсан нь манай эрүүл мэндийн салбарын чанар аюулгүй байдлыг олон улсын жишигт хүрэхэд нэгэн том алхам болсон.

Түүнчлэн Стандарт хэмжил зүйн газраас олон улсын ISO стандартын дагуу эмнэлэг эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжилж байна. Арьсны өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмн ISO 9001 стандартын дагуу үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.

Оношилгооны чанар-аюулгүй байдлыг сайжруулах, лаборатори хоорондын шинжилгээний зөрүүг арилгах зорилгоор 2008 оноос Эрүүл мэндийн яам, Японы "Сисмекс" корпорацитай гэрээ байгуулж чанарын гадаад үнэлгээний тогтолцоог бий болгосон. Үүний дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн чанарын хяналтын төв нь Японы Сисмекс корпорацитай хамтран гематологийн шинжилгээний гадаад хяналтыг хийж 200 гаруй эмнэлгийн лабораториуд тонтмол оролцдог болсон.

2012 оноос биохимийн 2015 оноос иммунологийн шинжилгээний чанарын гадаад хяналтыг улирал тутам явуулж хэвшээд байгаа юм. Лабораторийн шинжилгээний чанарын хяналтыг сайжруулах зорилгоор Халдварт өвчин судлалын үндэсний төв хепатит В болон С вирус, ДОХ, тэмбүү гэсэн 4 халдварт өвчний шинжилгээний хяналтыг, цус сэлбэлт судлалын үндэсний төв цус сэлбэлтийн чиглэлээр чанарын гадаад хяналтыг 25 цусний банкны хэмжээнд хийж, Ази, Австралийн чанарын гадаад хяналтын төвийн хяналтад хамрагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Олон улсын эрүүл мэндийн дүрмийн дагуу хөндлөнгийн хамтарсан үнэлгээг лабораторийн тогтолцоо, биоаюулгүй байдал, биохамгаалал, нянгийн тэсвэржилт гэсэн чиглэлээр явуулж, цаашид хийх ажлын төлөвлөгөөг гарган, өнөөгийн түвшинд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замаа тодорхойлон ажиллаж байна.

Манай улсад 1998 онд УИХ-аар батлагдан гарсан Эрүүл мэндийн тухай хуулиар Монгол улсын эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, эмнэлэгт магадлан итгэмжлэл олгох асуудлыг хуульчилж өгсөн.

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн холбогдох заалт, түүнийг дагалдан гарсан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмуудаар зохицуулагдаж байна.

2002 оноос эхлэн эрүүл мэндийн байгууллагуудад магадлан итгэмжлэл олгож эхэлсэн бөгөөд энэ хугацаанд улсын хэмжээнд 1000 гаруй байгууллага магадлан итгэмжлэгдсэн байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод 213, аймаг, орон нутагт 500 магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага ажиллаж байна. Магадлан итгэмжлэх тогтолцоо бүрдсэн нь эмнэлгийн тусламжийн чанар сайжрахад бодитой үр дүнгээ өгсөн боловч бид олон улсын жмшигт нийцүүлэн хөгжүүлэх, хөндлөнгийн бие даасан байдлыг хангах, суурь стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах шаардлатай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг цогцоор нь тасралтгүй сайжруулах нь бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, хөгжүүлэх.

ГУРАВ. ЗОРИЛТ

Үйл ажиллагааны зорилгыг биелүүлэхэд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана.

1. Чанар-аюул гүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
2. Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх соёлыг хөгжүүлэх;
3. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;
4. Магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох;
5. Тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах;
6. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх;

7. Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх;
8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах;
9. Өвчтний аюулгүй байдлыг хангах;
10. Эмнэлгийн аюулгүй байдлыг хангах;
11. Эмнэлгийн гамшгийн штабын үйл ажиллагааг эрчимжүүлэх.

ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын стратегийн үйл ажиллагааны хүрээг АНУ-ын Анагаах ухааны хүрээлэнгээс тодорхойлсон олон улсад өргөн ашигладаг STEEEP загварын зарчмыг баримталж хэрэгжүүлнэ.

- Аюулгүй байдал (Safety) - үйлчлүүлэгч болон эмч, эмнэлгийн ажилтнууд осол, алдаа, зөрчилд өртөхгүй байх;
- Цаг хугацаатай (Timely) - үйлчлүүлэгчид цаг хугацааны хоцрогдолгүй тусламж, үйлчилгээг хүргэх;
- Үр дүнтэй байдал (Effective) - үйлчлүүлэгчид хүргэсэн тусламж, үйлчилгээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байх;
- Үр ашигтай байдал (Efficient) - төлөвлөсөн үр дүнд хамгийн боломжит бага зардлаар хүрсэн байх;
- Тэгш, хүртээмжтэй байдал (Equitable) - ижил эмгэгтэй үйлчлүүлэгч бүр ижил тусламж, үйлчилгээ авах боломжоор хангагдсан байх;
- Үйлчлүүлэгч төвтэй байх (Patient centered)-тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн хэрэгцээнд үндэслэн зохион байгуулсан байх.

ТАВ. ХУГАЦАА: 2018 - 2022 он

ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

Тус үйл ажиллагааны зорилго, зорилтыг хангахад дараах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1. Ил тод, шударга засаглалыг дэмжих

- Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын Чанар-аюулгүй байдлын удирлагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх;

- Зэмлэн буруушаах арга барилаас татгалзаж дэмжлэгт удирдлагыг хөгжүүлэх;
- Эмчилгээ, үйлчилгээнд гарсан алдаа зөрчилд системийн анализ /дүн шинжилгээ/ хийх арга барилд суралцах;
- Удирдлагын бүх түвшинд эргэн мэдээлэх сувгуудыг бий болгох.

1.2. Чанар-аюулгүй байдлын үйл ажиллагаанд төвлөрлийг сааруулах, үйлчилгээ үзүүлэгчийг илүү татан оролцуулах

- Эмч, сувилагч, техникчийн ажлын байрны тодорхойлолтод чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг нэмж, мөрдүүлэх;
- Бүх шатны менежерүүд болон эмч, сувилагч нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар-аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлдэг болох;
- Чанар-аюулгүй байдлын үйл ажиллагаанд оролцсон ажилтнуудад урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх.

1.3. Баримт, бичгийг стандартжуулах

- Эрүүл мэндийн байгууллагын баримт бичгийн нэгдсэн кодын системийг нэвтрүүлэх заавар, журам боловсруулах.
- ЭМБ-ууд олон улсын ISO стандартын дагуу бичиг баримтын нэгдсэн кодын системийг нэвтрүүлэх.

Зорилт 2. Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх соёлыг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1. Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, хэрэгжилтийг сайжруулах

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй болон хоорондоо харилцах горимын дагуу эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх;
- Ёс зүйн сургалтыг анагаахын болон сувилахуйн боловсрол олгож байгаа их, дээд сургуулийн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт нэмж оруулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллага аливаа эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмийн үйлдвэрийг санаатай болон санамсаргүйгээр сурталчилахгүй байх.

2.2. Мэргэжлийн ёс зүйн хариуцлагыг сайжруулах

- Ёс зүйн алдаа зөрчлийг мэдээлэх, бүртгэх тогтолцоог бий болгож, мэдээний нэгдсэн сантай болох;

- Ёс зүйн алдааны эрэмбэ тогтоох хариу арга хэмжээг эрэмбийг харгалзан шийдвэрлэх. /хариуцлагыг/
- Ёс зүйн хариуцлагын шудрага тогтолцоог бий болгох, зөрчил гаргасан эмнэлгийн мэргэжилтэнд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх.

Зорилт 3. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Мэдлэг ур, чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх

- Анагаахын болон сувилахуйн төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт чанар-аюулгүй байдлын сургалтуудыг оруулах;
- Чанар-аюулгүй байдлын үндэсний сургагч багш нарыг бэлтгэх;
- Шинээр ажилд авсан ажилтнуудыг чиглүүлэх сургалтад заавал хамруулж, мэдлэг дадал олгож хэвшүүлэх.

3.2. Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг баталгаажуулах

- Байгууллага нь ажилтныг ажилд авахдаа мэргэжлийн баримт бичгүүдийг баталгаажуулдаг болох /төгссөн сургуулиаас тодорхойлолт авч баталгаажуулах.../;
- Мэс засал, мэс ажилбар хийдэг эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварын баталгаажуулалт хийдэг, үнэлдэг болох.

Зорилт 5. Тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж, хянаж сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Чанар-аюулгүй байдлын жишиг үзүүлэлтүүд /Benchmark үзүүлэлт/-ийг боловсруулах

- Чанар-аюулгүй байдлын жишиг үзүүлэлтүүдийг олон улсын, үндэсний, бүс нутгийн, байгууллагын түвшинд тодорхойлж үнэлгээнд ашиглах.

5.2. Чанар-аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж тогтмол хэмжиж, хянах

- Асуудалд чиглэсэн чанар-аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг салбарын, бүс нутгийн, байгууллагын, тасаг нэгжийн, хувь хүний болон хөтөлбөрийн түвшинд боловсруулж тогтмол хянах.

5.3. Асуудалд чиглэсэн чанар-аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

- Тулгамдсан ноцтой асуудлуудыг шийдэх төлөвлөгөө, хөтөлбөр батлан хэрэгжүүлэх.

5.4. Тусламж, үйлчилгээний үр ашгийг тооцдог болох

- Байгууллагууд зарим өртөг, зардал өндөртэй тусламж, үйлчилгээний өртгийн судалгаа хийж, үр ашгийг дээшлүүлэх арга замыг эрэлхийлдэг жишигт суралцах.

Зорилт 6. Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6.1. Оношилогоо, эмчилгээнд олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжуудыг мөрдөх

- Олон улсын хэмжээнд мөрдөж байгаа эмнэлзүйн удирдамж, гарын авлагыг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх, өөрийн орны нөхцөлд зохицсон удирдамж боловруулах тогтолцоог боловсронгуй болгох;
- Эрүүл мэндийн байгууллагуудыг олон улсын нээлттэй стандарт, удирдамжийн сан, вэб хуудас ашиглах боломжийг хангах, нөхцлийг бүрдүүлэх.

6.2. Өндөр үр дүнтэй шинэ технологи, эм, хэрэгслийг практикт шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх

- Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх журмыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх;
- Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн бүртгэл, нийлүүлэлтийг шуурхай болгох.

Зорилт 7. Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

7.1. Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид түргэн шуурхай, ээлтэйгээр зохион байгуулах

- Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн бүртгэл, тооцооны нэгжийг байгуулах.
- Тусламж, үйлчилгээний урсгалыг шуурхай болгох, хөтөчийн ажлын байрыг тодорхой болгож, сургалтад тогтмол хамруулах.

7.2. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хэмжих тогтолцоог бүрдүүлэх

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдлыг хэмжих стандарт асуумжийг боловсруулах;
- Эрүүл мэндийн байгууллагууд улирал бүр үйлчлүүлэгч болон эмч, ажилчаас сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийдэг, тусламж, үйлчилгээ, орчин нөхцлөө сайжруулах арга хэмжээ авч хэвших;
- Үйлчлүүлэгчийн болон эмч ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа хийдэг хөндлөнгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих.

7.3. Үйлчлүүлэгчийг шийдвэр гаргалтанд оролцуулдаг болох

- Байгууллагын дэргэд үйлчлүүлэгчийн зөвлөлийг байгуулж үйл ажиллагааг туршин явуулах.

7.4. Үйлчлүүлэгчийн гомдол, саналыг шуурхай хүлээн авч барагдуулдаг болох

- Үйлчлүүлэгчийн гомдол, саналыг шуурхай хүлээн авч барагдуулдаг болох;
- Эрүүл мэндийн байгууллагуудын асуудлууд болон үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгдөг, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг нэвтрүүлж нэгж байгуулах.

Зорилт 8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

8.1. Дүрэм, журмыг шинэчлэх

- Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, мөрдүүлэх.

8.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын бодит түвшинг тогтоох

- Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүд олон улсын INICC сүлжээнд гишүүн болж мэдээллээ өгдөг болох;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын хяналтын төв нь халдварыг идэвхитэй бүртгэж тандах онлайн вэб сүлжээнд шилжих;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын хяналтын төв нь INICC -тэй хамтран ажиллаж мэдээллээ солилцдог болгох;
- Олон эмэнд дасалтай MRSA болон VRE, ESBL+E.Coli, ESBL+Klebsiella spp, Acinetobacteria spp-ийн идэвхитэй тандалтыг эхлүүлэх.

8.3. Сэргийлэх арга хэмжээг сайжруулах

- Эмнэлгийн шалтгаант уушигны хатгаа (VAP) болон цусны замын халдвар (CLABSI)-аас сэргийлэх багцыг хэрэгжүүлж эхлэх;
- Нэг удаагийн хэрэгслийн хангамжийг сайжруулж хэрэглээний хяналтыг чангатгах.

8.4. Нянгийн антибиотикийн даслаас сэргийлэх

- Антибиотикийг эмийн санд зөвхөн жороор олгодог журмыг хэрэгжүүлэх
- Эмнэлэг бүр антибиотикийн бодлого хэрэгжүүлэх;
- Антибиотикийн нянгийн даслын тандалтыг нэвтрүүлэх;
- Антибиотикийг үндсэн, нэмэлт, нөөц гэж ангилан, нөөц антибиотикийн хэрэглээг хумьж, хяналтыг чангатгах, хэрэглээний удирдамжийг гаргах.
- ХӨСҮТ-ийн нян судлалын лаборатори мэдээгээ нэгтгээд, эргэн мэдээлж тандалтыг сайжруулах чиглэлд идэвхитэй ажиллах

Зорилт 9. Өвчтний аюулгүй байдлыг хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Стратегийн зорилт 9. Өвчтний аюулгүй байдлыг хангах

- Эмнэлгийн орчинд өвчтөн, үйлчлүүлэгч унахаас хамгаалахад шаардлагатай хэрэгслээр хангаж, нөхцөл бүрдүүлэх;
- Эмнэлгүүдэд өвчтөн, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд хяналт тавих, зөвлөгөө өгөх нэгжийг үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаатай нэгтгэн алба, нэгж байгуулах;
- Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааг, эмчилгээний аюулгүй байдлын хяналтын үйл ажиллагаатай уялдуулж өөрчлөн зохион байгуулах;
- Өвчтнийг таних, ялгах тэмдэглэгээ, систем нэвтрүүлэх;
- Өвчтний аюулгүй байдлын талаарх сургалтыг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаж оруулах.

Зорилт 10. Эмнэлгийн аюулгүй байдлыг хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

10.1. Эрсдэлийн удирдлагын бүтцийг шинэчлэх

- Эрсдэлийн хорооны бүтэц, чиг үүргийг яам, бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд шинэчлэх;
- Эмнэлгийн тасаг, нэгжүүдэд эрсдлийн багийг томилж эрсдэлийн тандалтыг эхлүүлэх.

10.2. Эрсдлийг тогтмол үнэлж, эрсдэлийг бууруулах

- Эрсдлийг мэдээлэх системийг салбар, байгууллагын түвшинд бүрдүүлэх
- Салбар болон байгууллагын түвшинд эрсдэлийн нэгдсэн сан үүсгэж, үнэлж, хянах;
- Эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг салбар, байгууллагын түвшинд боловсруулж хэрэгжүүлэх;
- Эмнэлгийн ажилтнуудыг эрсдлийн албан журмын болон нэмэлт сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх.

Зорилт 11. Эмнэлгийн гамшгийн штабын үйл ажиллагааг эрчимжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Гамшгийн штабын чиг үүрэгт жил бүр тодотгол хийж баталгаажуулах;
- Эрүүл мэндийн байгууллагуудад өндөр магадлалтай эрсдэлд хариу авах арга стандарт хэмжээний Кодын системийг нэвтрүүлж эхлэх;
- Эрүүл мэндийн байгууллагын онцгой байдал, гамшгийн үед ажиллах сургуулалтыг жилд 2-оос доошгүй удаа хийж хэвших.

Зорилт 4. Магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1. Магадлан итгэмжлэлийг сайн дурын болгох

- Эрүүл мэндийн даатгалын холбогдох хууль, журамд магадлан итгэмжлэлийн сайн дурын байдлыг хангах чиглэлээр өөрчлөлт оруулах
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь өндөр шалгуураар магадлан итгэмжлэгдсэн байгууллагад зэрэглэлтэйгээр урамшуулал олгодог болох

4.2. Магадлан, итгэмжлэлийн журам, шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэх

- Магадлан итгэмжлэлийн журам, суурь стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- Магадлан, итгэмжлэлийн шалгуур боловсруулах, хяналт үнэлгээ хийх, шинжээч бэлтгэх, ажилуулах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах.

ДОЛОО. САНХҮҮЖИЛТ

Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сан, гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудын тусламж, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Үйл ажиллагааны хэрэгжилтэд дунд хугацааны болон, төгсгөлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан, холбогдох байгууллагуудыг оролцуулан хийж гүйцэтгэнэ.

ЕС. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Одоогийн түвшин	Хүрэх түвшин				
			2018	2019	2020	2021	2022
1	Эмчилгээ, үйлчилгээнд гарсан алдаа зөрчилд системийн дүн шинжилгээ /анализ/ хийдэг эрүүл мэндийн байгууллагын тоо	5	10	21	38	50	80
2	Эмч, сувилагч, техникч нарын ажлын байрны тодорхойлолтонд чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаа оруулсан байгууллага	2	16	38	75	100	250
3	Бүх шатны менежерүүд болон эмч, сувилагч нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар-аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлдэг байгууллага	2	16	38	75	100	250
4	Эрүүл мэндийн байгууллагын баримт бичгийн нэгдсэн кодын системийг нэвтрүүлсэн байгууллага	1	8	16	38	54	85
5	Эмнэлгийн ажилтнууд хооронд болон үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны стандартыг тогтоосн, мөрдөж байгаа байгууллага	0	5	16	21	36	45
6	Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт чанар-аюулгүй байдлын сургалт оруулсан сургуулийн тоо	0	2	4	6	8	10
7	Мэс засал, мэс ажилбар хийдэг мэргэжилтний ур чадварын баталгаажуулалт хийдэг, үнэлдэг байгууллага	1	10	21	31	40	50
8	Чанар-аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг байгууллага, тасаг нэгжийн, хувь хүний түвшинд хянах хөтөлбөртэй байгууллага	1	16	38	45	55	60
9	Тулгамдсан ноцтой асуудлуудыг шийдэх хөтөлбөр, журам боловсруулж, хэрэгжүүлж буй байгууллага	5	10	21	40	50	60
10	Олон улсын нээлттэй стандарт,	3	10	20	30	35	45

	удирдамжийн сан, вэб хуудас ашиглах боломжийг хангасан байгууллага						
11	Үйлчлүүлэгчийн бүртгэл, тооцосны нэгжтэй эмнэлгийн тоо	5	5	10	15	20	30
12	Улирал бүр үйлчлүүлэгч болон эмч, ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дутагдлаа сайжруулах арга хэмжээ авдаг байгууллагын тоо	36	40	50	60	80	90
13	Олон улсын INICC сүлжээнд гишүүн болж мэдээллээ өгдөг байгууллагын тоо	2	4	6	8	10	20
	Өвчтнийг ялган таних бар кодын систем нэвтрүүлсэн	2	3	6	8	10	12
14	Үйлчлүүлэгч унахаас сэргийлэх, унах эрсдлийг хянах хөтөлбөр хэрэгжүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоо	1	16	21	38	48	58
15	Гар угаах хөтөлбөр хэрэгжүүлж, гар ариутгахыг хянах тогтолцоо бүрдүүлсэн байгууллагын тоо	5	10	20	30	40	50
16	Эмнэлгүүдэд өвчтөн, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг зохицуулах, зөвлөгөө өгөх нэгжтэй байгууллагын тоо	0	2	5	10	20	40
17	Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааг, эмчилгээний чанар- аюулгүй байдлын хяналттай уялдуулж зохион байгуулсан эмнэлгийн тоо	3	10	15	25	35	45
18	Эрүүл мэндийн байгууллагуудад өндөр магадлалтай эрсдэлд хариу авах арга стандарт хэмжээний Кодын системийг нэвтрүүлсэн байгууллагын тоо	1	15	25	35	45	55
19	Эрсдлийн нэгдсэн сан үүсгэж, үнэлж, хянах тогтолцоо бүрдүүлж, төлөвлөгөөтэй ажилладаг байгууллагын тоо	6	10	20	30	40	50
20	Эмнэлгийн эмч, ажилтнуудыг эрсдлийн албан журмын болон нэмэлт сайн дурын даатгалд хамруулж байгаа байгууллагын тоо	0	2	4	8	16	32

АРАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. " Эрүүл мэндийн тухай" хууль. 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдөр
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль 2016. №21
3. "Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого", ЭМЯ Улаанбаатар хот
4. Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд. 2015-2017 он
5. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого. 2016
6. Joint commission International Accreditation Standards for Hospitals. Illinois, JCR
7. Lisa Schilling (2009). Implementing and sustaining Improvement in Health Care. Illinois, JCR
8. WHO/WPRO. Patient safety training materials. (2017)
9. WHO/WPRO. Hospital Quality and Safety Management course training materials (2017)
10. WHO. Universal Health Coverage booklet (2016)
11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах тухай. ЭМСайдын 2007 оны 275 тоот тушаал.
12. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын дотоодын хяналтыг эрчимжүүлэх тухай 2010 оны 225 тоот тушаал.
13. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлын чиглэлээр эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд тулгамдсан асуудлууд, авах арга хэмжээ. Тайлан, илтгэл (2012)

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны
18 өдрийн 4/58-р тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР-АЮЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2018-2022 ОН)

№	Стратеги	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага				Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	
					Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Бусад оролцогч байгууллага				
Зорилт 1. Чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох											
1.1	Ил тод, шударга засаглалыг дэмжих	Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын Чанар-аюулгүй байдлын удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх	Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 01 сарын 17-ны өдрийн 25 тоот хамтарсан "Чанарын албаны дүрэм батлах тухай" 2012 оны 1 сарын 17-ны 06/25 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах	2018	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Батлагдсан тушаал	ЭМС-ын тушаал гарсан байна	ЭМС-ын чанар аюулгүй байдал сайжирна	
			Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 сарын 21-ний өдрийн "Хөтөлбөрийн загвар шинэчлэн батлах тухай" 437 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах	2018	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Батлагдсан тушаал	ЭМС-ын тушаал гарсан байна		
			Эмчилгээ, үйлчилгээнд гарсан алдаа, зөрчилд системийн анализ хийх арга барилд суралцах	2018-2022	ЭМХТ	НЭМГ	ЭМБ	Сургалт зохион байгуулах төлөвлөгөө			

			ЭМС-ын 2012 оны 274 дүгээр тушаалыг шинэчлэн боловсруулах. Эмчилгээ, үйлчилгээнд гарсан алдаа зөрчлийг бүртгэн мэдээлж, алдаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх./Алдаа зөрчлийг бүртгэх хуудасны загварыг шинэчлэх/	2018-2019	ЭМХТ	ЭМБ		ЭМС-ын тушаал	ЭМБ-д ноцтой тохиолдлуудад RSA шинжилгээг 100% хийж хэвшсэн байна.
		Удирдлагын бүх түвшинд эргэн мэдээлэх сувгуудыг бий болгох	Байгууллага бүр мэдээлэл солилцох журам боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Уулзалт, мэйл хаяг, тайлан, дотоод сүлжээ	ЭМБ бүр 2-оос доошгүй эргэн мэдээлэх, мэдээлэл солилцох сувгийг бүрдүүлсэн байна.
			Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод чанар сайжруулах чиглэлээр хялх ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөө болон гэрээнд тусгаж мөрдүүлэх.	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Шинэчлэгдсэн ажлын байрны тодорхойлолт	ЭМБ нь ажилтны АБТ-ыг 100% шинэчилсэн байна.
1.2.	Чанар аюулгүй байдлын үйл ажиллагаанд төвлөргийг сааруулах, үйлчилгээ үзүүлэгчийг илүү татан орсонцуулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод ЧАБ-ын чиглэлээр хийсэн ажлыг нэмж оруулах	Бүх шатны менежерүүд болон эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-ын чиглэлээр хийсэн ажлыг үнэлдэг болсх	2018-2022	ЭМБ	ЭМХТ		Гүйцэтгэл-ийн үнэлгээний шалгуур	ЭМБ нь ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-н шалгууруудыг тусгадаг болсон байна.
			ЧАБ-ын чиглэлээр үр дүнтэй ажил хийж идэвхи зүтгэлтэй ажилласан эмч, ажилтнуудад урамшуулал олгодог болох эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх	2018-2022	ЭМБ			Эрүүл мэндийн байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулах	ЭМБ бүр чанар аюулгүй байдлын үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон, сайн ажилласан эмч, мэргэжилтэн, ажилтнуудад урамшуулал олгодог болсон байна.
1.3.	Баримт, бичгийг стандартжуулах	ЭМБ-ын баримт бичгийн нэгдсэн кодын системийг нэвтрүүлэх	Дотоод баримт бичгийн нэгдсэн кодын системийг нэвтрүүлэх журам боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Шинээр боловсруулсан заавар, журам	Кодын нэгдсэн систем бүрдүүлэх заавар, журам боловсруулсан байна.

[illegible]

Зорилт 3. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх

		Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрт ЧАБ-н сургалтыг оруулах	Анагаахын сургуулиудын төгсөлтийн өмнөх болон дараах хөтөлбөрт "Чанар аюулгүй байдал" сургалт оруулах талаар АШУУИС-ын удирдлагууд, сургалтын албатай уулзалт зохион байгуулах	2020	ЭМЯ БСШУЯ	АШУУИС		Зөвөлгөөн Шийдвэр Хөтөлбөр Хичээл заагдсан тоо	Тушаал, шийдвэрүүд гарч төгсөлтийн өмнөх болон дараах сургалтуудад ЧАБ-н сэдвүүд заагдаж эхэлсэн байна
3.1	Мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх	Мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх	ОУ-ын чанарын холбоонд элсэн орж чанар, аюулгүй байдлын чиглэлээр зохион явуулдаг сургалтанд хамрагдах	2018	ЭМЯ	ЭМХТ		Сургалтаар бэлтгэх	Чанар-аюулгүй байдлын үндэсний сургалч багш бэлтгэгдсэн байна
		ЧАБ-ын үндэсний сургалч багш нарыг бэлтгэх	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран чанар хариуцсан мэргэжилтнүүдийг чанар аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд хамруулах	2018-2020	ЭМЯ	ЭМХТ			
		Шинээр ажилд авсан ажиглагчид ажиглагч чиглүүлэх сургалтанд сургадаг болох	Эрүүл мэндийн ажилтныг шинээр ажилд орохын өмнө болон жилд 2-оос доошгүй удаа чанар аюулгүй байдлын ажлын байрны сургалтанд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах	2018-2019	ЭМЯ	ЭМБ	Мэргэжлийн нийгэмлэг холбоод	Шинээр ажилд орсон хүмүүсийг 100 хувь сургалтад хамруулах	Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын талаар мэдлэг ур, чадвар сайжирна
		Байгууллага нь ажилтныг ажилд авахдаа мэргэжлийн баримт бичгүүдийг баталгаажуулдаг болох	Байгууллага нь ажилтныг ажилд авахдаа мэргэжлийн баримт бичгүүдийг баталгаажуулдаг, хэрэгжүүлэх журам боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ		Тушаал журам	Эмч ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг бодитсор үнэлдэг болно
3.2	Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадварыг баталгаажуулах	Мэс засал, процедур хийдэг мэргэжилтнүүдэд ур чадварын баталгаажуулалт хийдэг, үнэлдэг болох	Ур чадварын баталгаажуулалтын журм үнэлгээний боловсруулах	2019	ЭМЯ	ЭМХТ		Тушаал журам	ЭМС-ын тушаалаар үлгэрчилсэн журам батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна

Зорилт 4. Магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох

4.1	Магадлан итгэмжлэлийг тогтолцоог боловсронгуй болгох бүрдүүлэх	Холбогдох хууль, журамд магадлан итгэмжлэлийн тогтолцоог сэйжруулах	Магадлан үндэсний бүрдүүлэх чадваржуулах чиглэлээр боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	Шийдвэр гаргах	Төсөл боловсрогдож шийдвэрлэгдсэн байна. Магадлан итгэмжлэлийн тогтолцоо боловсронгуй болсон байна.
		Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад зэрэглэлтэйгээр ЭМД-ын санхүүжилт, урамшуулал олгодог болох	Журам боловсруулах	2019-2020	ЭМЯ	МИҮЗ, МНХ	Тушаал журам	Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-гуудад урамшуулал олгодог тогтолцоо бүрдсэн байна.
4.2	Магадлан, итгэмжлэлийн журам шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэх	Магадлан итгэмжлэлийн журам, суурь стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах	ЭМС-ын 2014 оны 237 дугаар тушаал "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ыг шинэчлэн батлах	2019	ЭМЯ, ЭМХТ	СХЗГ, МНХ	Шинэчлэгдсэн журам, стандартууд	Магадлан итгэмжлэлийн суурь стандарт журам батлагдан хэрэгжсэн байна.
		Магадлан, итгэмжлэлийн шалгуур боловсруулах, хяналт үнэлгээ хийх, шинжээч бэлтгэх, ажлуулах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт батлах тухай ЭМС-ын 2014 оны 07 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах	2018-2019	ЭМЯ, ЭМХТ	СХГ, МНХ	Шинэчлэгдсэн шалгуур үзүүлэлт	Тогтолцоо боловсронгуй болсон байна
Зорилт 5. Тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах								
5.1	Чанар-аюулгүй байдлын жишиг үзүүлэлтүүд /Benchmark үзүүлэлт-ийг боловсруулах	Чанар-аюулгүй байдлын жишиг үзүүлэлтүүдийг олон улсын, үндэсний, бус нутгийн, байгууллагын түвшинд тодорхойлж үнэлгээнд ашиглах	ЧАБ-ын Benchmark жишиг үзүүлэлтүүдийг чиглэл бүрээр боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	Шалгуур үзүүлэлт	ЧАБ-ын Benchmark үзүүлэлтүүдийг тодорхойлж үнэлгээнд ашиглаж хэвшсэн байна.
5.2	ЧАБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж тогтмол хэмжих	Асуудалд чиглэсэн ЧАБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг салбарын, бус нутгийн, байгууллагын, тасаг нэгжийн, хувь хүний болон хөтөлбөрийн түвшинд боловсруулж тогтмол хянах	ЧАБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг шинээр (нийтлэг болон өвөрмөц) боловсруулж батлуулах	2018-2019	ЭМЯ	ЭМБ	Шинэчлэн боловсруулсан шалгуур үзүүлэлт	Бүх түвшинд асуудалд чиглэсэн 4 төрлийн шалгууруудыг үнэлгээнд ашиглаж хэвшсэн байна.

5.3	Асуудалд чиглэсэн ЧАБ-ын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	Тулгамдсан ноцтой асуудлуудыг шийдэх хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлдэг журмыг батлан хэрэгжүүлэх	ЭМБ нь туламдсан нэцтэй асуудлаа шийдвэрлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж тогтмолжуулах	2018-2020	ЭМБ	ЭМХТ	Хөтөлбөр	ЭМБ-ын чанарын алба жил бүр хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнг тооцдог болсон байх
5.4	Тусламж, үйлчилгээний үр ашгийг тооцдог болох	Байгууллагууд зарим өртөг, зардал өндөртэй тусламж, үйлчилгээний өртгийн судалгаа хийж үр ашгийг дээшлүүлэх зэргэ замыг эрэлхийлдэг жишигт суралцах	Чанарын албанд санхүүгийн аудиторыг оруулж, үйл ажиллагаа явуулж (өртгийн болон үр ашгийн судалгаа) хийдэг болгох (Чанарын албаны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах)	2019-2020	ЭМЯ	ЭМХТ	Шинэчлэгдсэн тушаал Өртөг, үр ашгийн судалгаа Үр дүн	ЭМБ нь жилд 2 удаа өртгийн судалгаа хийж, үр дүнг тооцдог болсон байна.
Зорилт 6. Нөтөлгөөнд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх								
6.1	Онцгойлоо, эмчилгээнд олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжуудыг мөрдөх	Эмнэлзүйн удирдамж боловруулах, орчуулж хөрсөн дээр буулгах үйл ажиллагаанд мэргэжлийн нийгэмлэг, холбоодыг татан оролцуулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх	ОУ-ын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг тогтолцоог бүрдүүлэх	2020-2022	ЭМЯ	ЭМХТ	Нэвтрүүлсэн стандартын тоо	Олон улсын түвшинд мөрдөж байгаа эмнэлзүйн удирдамжуудыг өөрийн хөрсөн дээр буулган хэрэгжүүлдэг болсон байна.
		Стандарт удирдамж боловсруулах орчуулах туршиж, нэвтрүүлэх төслийг жил бүрийн төсөвт тусладаг болох	2019-2022	ЭМЯ	МНХ	ЭМБ	Батлагдсан төсөв	
	Эрүүл мэндийн байгууллагуудыг олон улсын нээлттэй стандарт, удирдамжийн сан, вэб хуудас ашиглах боломжийг бүрдүүлэх	Бүх шатны байгууллагуудад ОУ-ын эмнэл зүйн нээлттэй стандарт, удирдамжийн сан, вэб хуудас ашиглах боломжийг бүрдүүлэх	2017-2018	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Стандарт удирдамжийн санд нэвтэрч бүрэн ашиглах боломж бүрдүүлэх	2-3 дугаар шатлалын эмнэлгүүдийн 50-аас доошгүй хувь нь олон улсын эмнэлзүйн удирдамжийн санг ашиглаж эхэлсэн байна.

6.2	Өндөр үр дүнтэй шинэ технологи, эм, хэрэгслийг практикт шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх	Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, нэвтрүүлэх журмыг олон улсын жишгт нийцүүлж шинэчлэх	Журмыг боловсруулах шинэчлэн	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Шинэчлэгдсэн журам	Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, нэвтрүүлэх журмыг шинэчилсэн байна. Түргэвчилсэн бүртгэл хийдэг болсон байна.
		Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, нэвтрүүлэх журмыг олон улсын жишгт нийцүүлж шинэчлэх	Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн бүртгэл, импортыг шуурхай болгох, эмч мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх технологи аргачлалыг боловсруулах /	2020-2022	ЭМЯ	ЭМХТ		Бүртгэгдсэн шинэ эмийн жагсаалт	Шинэ эмийн бүртгэл болон хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн импортыг шуурхай болгосон байна.

Зорилт 7. Үйлчилүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх

7.1	Тусламж, үйлчилгээг үйлчилүүлэгчид түргэн шуурхай, ээлтэйгээр зохион байгуулах	ЭМБ-д үйлчилүүлэгчийн бүртгэл, торцсоны нэгжийг байгуулах	Бүх шатны ЭМБ-уудад "Цахим эрүүл мэнд хөтөлбөр"-ийг нэвтрүүлэх, бүртгэл торцсоны нэгжтэй байх	2020-2022	ЭМЯ	ЭМХТ	ЭМБ	Цахим эрүүл мэнд хөтөлбөр	ЭМБ-ууд үйлчилүүлэгчтэй харилцах нэгжтэй болсон байна.
		Тусламж, үйлчилгээний урсгалыг шуурхай болгох, хөтөчийг бий болгох	Үйлчилүүлэгчтэй харилцах нэгж байгуулж, хөтөчийн үйлчилгээг үзүүлж хэвшэх	2018-2022	ЭМБ			Үйлчилүүлэгчтэй харилцах нэгжтэй байгууллагын тоо хөтөч үйлчилгээний байгууллагын тоо	ЭМБ-ууд нь хөтөчийн үйлчилгээтэй болсон байна.
7.2	Үйлчилүүлэгчийн сэтгэл ханамжийн стандарт асуумжийг боловсруулах	Үйлчилүүлэгчийн сэтгэл ханамжийн стандарт асуумжийг боловсруулах	ЭМС-ын 13 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ		Шинэчлэгдсэн тушаал, журам	Үлгэрчилсэн асуумж боловсруулсан байна.
		Үйлчилүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийдэг хөндлөнгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих	Хөндлөнгийн байгууллагууд үйлчилүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх бололцоогоор хангах талаар журамд нэмэлтээр оруулах	2018-2019	ЭМЯ	ЭМХТ	МНХ	Шинэчлэгдсэн журам	Сэтгэл ханамжийн судалгаа хийдэг хөндлөнгийн байгууллагууд бий болгосон байна.

7.3	Үйлчилгээний шийдвэр гаргалтанд оролцуулдаг болох	Байгууллагын үйлчилгээний байгуулж туршин явуулах	Дэргэд зөвлөлийг ажиллагааг	Үйлчилгээний зөвлөлийг ЭМБ-дэд зохион байгуулах ажлыг эхлүүлэх	2019-2022	ЭМЯ	ЭМХТ	МНХ	Үйлчилгээний зөвлөл байгуулсан ЭМБ-ын тоо	Байгууллага нь үйлчилгээний зөвлөлтэй болж жилд 1 удаа хуралдуудаг болсон байна.
7.4	Үйлчилгээний гомдол, саналыг шуурхай хүлээн авч барагдуулдаг болох	Үйлчилгээний гомдол, саналыг шуурхай хүлээн авч барагдуулдаг болох	Үйлчилгээний гомдол, мэргэжлийн алдаанаас суралцах, гомдол саналд хариу өгч асуудлыг нь шийдэхээр ажилладаг байгууллагын соёлыг нэвтрүүлэх сургалт зохион байгуулах	2018-2020	ЭМБ	МНХ			Тухайн байгууллагын эвчлэлийн 80-с доошгүй хувийг хамруулсан байна	Эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой харилцаа, хандлагын зөрчил буурсан байна.
				ЭМБ болон үйлчилгээний Хууль зүйн зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлах нэгжийг байгуулах	2019-2022	ЭМБ			Хууль зүйн зөвлөгөө өгдөг, эвлэрүүлэн зуучилдаг нэгжийн тоо	Эрүүл мэндийн байгууллагуудад эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа нэвтэрсэн байна
Зорилт 8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах										
8.1	Дүрэм, журмыг шинэчлэх	ЭМБ-ын бүтэц, үйл ажиллагааны стандартад халдвараас сэргийлэх стандартыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх	Эмнэлэг бүрт халдвар хяналтын тогтолцоог төрөлжүүлж гаргах /шинэ технологийг уялдуулан/	2019-2022	ЭМЯ	ЭМБ			Шинэчлэгдсэн стандарт	МНС Бүтэц, үйл ажиллагааны стандартууд шинэчлэгдсэн байна.
8.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын бодит түвшинг тогтоох	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүд олон улсын INICC сүлжээнд гишүүн болж мэдээлэл өгдөг болох	Мэдээлж, хариу арга хэмжээ авсан байдлыг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний "САЙН" оноо болгон дүгнэдэг болох	2019-2022	ЭМЯ	ЭМБ			Олон улсын INICC сүлжээнд гишүүн болсон байгууллагын тоо	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн 50% нь олон улсын INICC сүлжээнд гишүүн болсон байна.
		Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын бодит түвшинг тогтоох	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын хяналтын тсв нь эмнэлгийн халдварыг идэвхтэй бүртгэж тандах онлайн вэб сүлжээнд шилжих	2018-2019	ЭМН	ХӨСҮТ			Боловсруулсан аргачлал	ХӨСҮТ-ийн ЭТҮХХТСТасаг нь INICC-д гишүүн болж мэдээлэл авдаг болсон байна.

		ХӨСҮТ-ийн ЭТҮХХТСТасаг нь эмнэлгийн хадварыг идэвхитэй бүртгэж тандах онлайн вэб сүлжээнд шилжих	Нэгдсэн програми хангамж суурилуулах	2018-2022	ЭМЯ	ХӨСҮТ		Цахим сүлжээ	ХӨСҮТ-ийн ЭТҮХХТСТасаг нь ЭШХ бүртгэх сүлжээтэй болсон байна.
8.3		Олон эмэнд дэсвэртэй MRSA болон VRE ESBL+Klebsiella spp, Acinetobactera spp-н идэвхитэй тандалтыг эхлүүлэх	Мэдээлэлийн урсгалыг тодорхой болгож журамлах	2020	ЭМЯ	ХӨСҮТ	ЭМБ	INICC сүлжээнд хамрагдсан байгууллага, Тандалтын мэдээ өгдөг байгууллагын тоо	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн 50% нь INICC сүлжээнд MRSA болон VRE-ESBL+E.Coli, ESBL+Klebsiella spp, Acinetobactera spp-ийн идэвхитэй тандалтын мэдээ өгдөг болсон байна
8.4	Сэргийлэх арга хэмжээг сайжруулах	Эмнэлгийн шалтгаант уушмын хатгаа (VAP) болон цусны замын халдвар (CLABSI)-аас сэргийлэх багцыг хэрэгжүүлж эхлэх	ЭМБ-ын шалтгалыг харгалзан журамлаж өгөх	2020-2022	ЭМЯ	ХӨСҮТ	ЭМБ	Хэрэгжүүлсэн багц	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн VAP, CLABSI багцыг хэрэгжүүлсэн байна.
		Нэг удаагийн хэрэгслийн хангамжийг сайжруулж хэрэглээний хяналтыг чангатгах	ЭМБ-ын тусламж, үйлчилгээний цар хүрээнд тохируулан нэг удаагийн хэрэгслийн нөмрийн төлөвлөлт, хуваарилалт хийх журам тогтоох	2019-2022	ЭМЯ			Журам	ЭМБ-ын 80% нь нэг удаагийн хэрэгсэлд бүрэн шилжсэн байна.

	Эмнэлгүүдэд антибиотикийн нягсийн даслын тандалтыг нэвтрүүлэх	Тусгайлан ажиллан бэлдэх	2020-2022	ЭМЯ	ХӨСҮТ	Тандалт нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагууд	Улсын хэмжээнд антибиотикийн тандалтын мэдээ гардаг болсон байна.
8.5	Нягсийн антибиотикийн дасалаас сэргийлэх	ЭМБ-ын цогцол бүрээр нөөцийн хуваарилалт хийж өгөх	2019-2022	ЭМЯ	ЭМБ	Удирдамж	Антибиотикийн хэрэглээний журам шинэчлэгдэж хэрэглээнд хяналт тогтмол хийдэг болсон байна.
	Эмнэлэг бүр антибиотикийн бодлого хэрэгжүүлэх	Заавар, зөвлөмж гаргах	2018-2022	ЭМБ	ЭМХТ	Журам загвар	Эмнэлэгт ирсэн хүн бүрт антибиотик хэрэглэхээ больсон байна.
Зорилт 9. Өвчний аюулгүй байдлыг хангах							
9.1	Эмнэлгийн орчинд өвчтөн, үйлчлүүлэгч унахаас хамгаалахад шаардлагатай хэрэгслээр хангаж нөхцөл бүрдүүлэх	Уналтаас өвчнийг ажиглах, үнэлэх, - сэргийлсэн бүх л өрчин нөхцлийг бүрдүүлэх /шал, ор, суултуу, тэргэнцэр.../ өвчтөнд болон сайтар бүлийнхэнд нь тайлбарлах зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам батлуулж хэрэгжүүлэх	2019-2020	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	Журам ЭМБ-д хэрэгжиж эхэлсэн байна
9.2	Эмнэлгүүдэд өвчтөн, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлад хяналт тавих, өгөх нэгжийг үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаатай нэгтгэн алба, нэгж байгуулах	ЭМБ-ын бүтцэд Өвчтөн, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлад хяналт тавих, зөвлөгөө өгөх нэгж байгуулах үлгэрчилсэн загвар батлах	2019-2020	ЭМЯ	ЭМБ	ЭМСайдын тушаал	ЭМБ-д хэрэгжиж эхэлсэн байна.

9.3	Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааг, эмчилгээний аюулгүй байдлын хяналтын үйл ажиллагаатай уялдуулж өөрчлөн зохион байгуулах	Эмийн санд 4 дахиад хяналтыг нэвтрүүлэх	2019-2022	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	Эмийн аюулгүй байдал сайжирсан байна.	Эмчилгээний аюулгүй сайжирна. чанар байдал
9.4	Өвчний аюулгүй байдлын талаарх сургалтыг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаж оруулах	Анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг МСЗ, удирдлагуудтай нь эвшилцөх арга хэмжээ авах	2019-2020	ЭМЯ	Анагаахын сургуулиуд	ЭМХТ	Сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжсэн байна.	Суралцаж байгаа оюутнууд тусламж, үйлчилгээний аюулгүй талаар болно
9.5	Өвчнийг таних, ялгах тэмдэглэгээ, систем нэвтрүүлэх	Өвчний гаранд бар код зүүх, эсвэл өнгөөр ялгах таних тэмдгийг бүх эмнэлгүүд ажиллагаандаа нэвтрүүлэх	2019-2020	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	Хэрэгжиж хэвшсэн байна	Өвчний аюулгүй байдал сайжирна.
Зорилт 10. Эмнэлгийн аюулгүй байдлыг хангах								
10.1	Эрсдэлийн удирдлагын бүтцийг шинэчлэх	Эрсдэлийн хорооны бүтэц, чиг үүргийг яам, бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд шинэчлэх	2018-2019	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМСайдын тушаал	Үлгэрчилсэн журам гарч ЭМБ-дэд хэрэгжүүлж эхлэсэн байна.

		Эмнэлгийн тасаг, нэгжүүдэд эрсдлийн багийг томилж эрсдэлийн тандалтыг эхлүүлэх	Эрсдэлийн хариуцсан ажилтан, АБТ зэргийг тодорхой болгох	2019	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМС-ын тушаал	ЭМБ нь тасаг, нэгж бүрт багтай болж эрсдэлийн тандалт хийдэг болсон байна.
		Эрсдэлийг мэдээлэх системийг салбар, байгууллагын түвшинд бүрдүүлэх	Бүртгэх, мэдээлэх, тайлагнах үйл ажиллагааг журам боловсруулах	2018-2019	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	Журам батлагдсан байна.	Бүх түвшинд эрсдэлийг мэдээлэх онлайн системийг байгуулсан байна.
		Салбар болон байгууллагын түвшинд эрсдэлийн нэгдсэн сан үүсгэж, үнэлж, хянах	"Сан"-г хэрхэн ажиллуулах талаар журам боловсруулах	2019	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМС-ын тушаал	ЭМБ нь эрсдэлийн сантай болсон байна.
10.2	Эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлийг бууруулах	Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг салбар, байгууллагын түвшинд боловсруулж хэрэгжүүлэх	Эрсдэлийн удирдлагаар ажлын байрны сургалтыг хийдэг болох. (сургалтын хөтөлбөр боловсруулах)	2020	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	Журам батлагдсан байна	Бүх түвшинд эрсдэлийг бууруулах төлөвлөгөөтэй болсон байна.
		Эмнэлгийн ажилтнуудыг эрсдэлийн албан журмын болон нэмэлт сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх	Даатгалын тогтолцооны журам, дүрэм боловсруулах /гадаад улс орнуудаас туршлага судлах/	2020-2022	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМС-агийн тушаал	Гурав болон хоёрдугаар шатилгын эмнэлгүүдийн 50% нь эрсдэлийн даатгалд хамрагдсан байна.

		ЭМЯ, ЭМГ эрүүл мэндийн байгууллагын Гамшгийн штабын бүтэц, чиг үүргийг шинэчлэн боловсруулах	Байгууллагын гамшгийн штабын бүтэц, чиг үүргийг бүр шинэчлэн баталгаажуулах	2018-2022	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМСайдын тушаал	ЭМСайд ба ОБЕГ-ын даргын хамтарсан тушаалаар үлгэрчилсэн журам гарч ЭМБ-д хэрэгжүүлж эхэлсэн байна.
	Эмнэлгийн гамшгийн штабын ажиллагааг эрчимжүүлэх үйл	ЭМЯ, ЭМГ эрүүл мэндийн байгууллагын онцгой байдал, гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг үлгэрчилсэн боловсруулах	Эрүүл мэндийн байгууллагын онцгой байдал, гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулах	2018-2022	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМСайдын тушаал	ЭМБ бүр онцгой байдал, гамшгийн үед ажиллах төлөвлөгөөнд жил бүр шинэчлэлт хийж хэвшсэн байна.
		Эрүүл мэндийн байгууллагууд өндөр магадлалтай эрсдэлд хариу авах арга стандарт хэмжээний Кодын системийг нэвтрүүлж эхлэх	Кодын систем нэвтрүүлэх журам боловсруулах	2019-2020	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМСайдын тушаал	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн 50% нь Гал болон амлуулах тусламжийн Кодыг нэвтрүүлсэн байна
		Эрүүл мэндийн байгууллагын онцгой байдал, гамшгийн үед ажиллах сургуулалтыг жилд 2-оос доошгүй удаа хийж хэвших	Эмнэлэг бүр өөр өөр сэдвээр сургуулалт хийж харилцан солилцдог болох	2018-2022	ЭМЯ	ЭМБ	ЭМХТ	ЭМСайдын тушаал	Гурав болон хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн 50% нь онцгой байдал, гамшгийн сургуулалтыг жилд 2 удаа хийж хэвшсэн байна.